



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

“Шинэст” ХК-ийн нэгдмэл сонирхолтой хувьцаа  
эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх,  
хувьцааг худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Шинэст” ХК-ийн нийт гаргасан 184,723 ширхэг хувьцааны 81,34 хувь буюу 150,264 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Э.Анар, Т.Энхбат, Д.Бурмаа, Б.Ачтуяамаа, Я.Дамдимаа нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 18,66 хувь буюу 34,459 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 400 /дөрвөн зуу/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Шинэст” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Э.Анар/-д үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах.

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000134